

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2023.04.07

Тендер шалгаруулалтын нэр: 18-р хороо, Бэлхийн 46-р гудамжийг Гүнжийн гудамжтай холбосон гүүр, байгууламж барих

Тендер шалгаруулалтын дугаар: СБДХААА/202312016

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг “18-р хороо, Бэлхийн 46-р гудамжийг Гүнжийн гудамжтай холбосон гүүр, байгууламж барих” ажил гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: Үгүй

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Цахим тендерт оролцогч нь 1 000 000 /нэг сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

**Тусгай зөвшөөрөл:** Зам тээврийн яамнаас олгодог **2.8.2.5 Бүх төрлийн гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам барих**

Тендерийг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 09цаг 00 минутаас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн, 09 цаг 05 минутад зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: Үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
7 дугаар хороо, Денверийн гудамж, Сүхбаатар дүүргийн  
Засаг даргын Тамгын газрын байр 205 тоот  
Утас:70107632